



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 07 сарын 18 өдөр

Дугаар A/262

Улаанбаатар хот


Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2019 оны A/262 дугаар захирамжаар эрх шилжин ирсэн Баянгол дүүргийн 3 дугаар хороо, Нарны хороололд "960 хүүхдийн ерөнхий боловсролын сургууль, 280 хүүхдийн цэцэрлэгийн барилга, тоног төхөөрөмж, гадна инженерийн шугам сүлжээ, тохижилтын ажлын хамт худалдан авах" ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны дарга Д.Ариунбаатар нь ажил үүргээсээ чөлөөлөгдсөнтэй холбоотойгоор 2019 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн A/120 дугаар тушаалын хавсралтаар байгуулагдсан "Үнэлгээний хорооны дарга – нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын орлогч даргын үүрэг гүйцэтгэгч Д.Ариунбаатар" гэснийг "Үнэлгээний хорооны дарга - Өмчийн ашиглалт, удирдлагын газрын орлогч даргын үүрэг гүйцэтгэгч Д.Рэнцэнбямба" гэж өөрчилсүгэй.

2. Батлагдсан төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль, журамд заасны дагуу зохион байгуулж ажиллахыг Үнэлгээний хорооны дарга Д.Рэнцэнбямбад даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

115050000849